



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 6 сарын 01 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

「Нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрийг  
хүчингүй болгож, нийтэд мэдээлэх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5, 33 дугаар зүйлийн 33.1.3, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 3 дугаар тойрогт “Сахигтун! Үндсэн хуулийн 19” эвслээс нэр дэвшигчээр бүртгэгдсэн Доржпаламын Мөнх-Эрдэнийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдсон тул Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 117 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаарт бичигдсэн Доржпаламын Мөнх-Эрдэнэд холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Нэр дэвшигчийг бүртгэсэн тогтоолыг хүчингүй болгосонтой холбоотойгоор уг шийдвэрийг нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Д.Баяндүүрэн/-нд даалгасугай.

ДАРГА Ч. САРТАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

Ц.БОЛДСАЙХАН



000569